

**Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах шугамын БОННБУ-ний тайлан –Нийгмийн суурь  
судалгааны төлөвлөгөө**

Огноо: 2020 оны 5-р сарын 12 Цаг: 10- 11

Байршил: ЦДҮС-н байр, Дашдаваагийн ажлын өрөө

Хурлын бүрэлдэхүүн:

1. Дашдаваа Орлогч захирал, Ерөнхий инженер.
2. Ариунболд, Ажлын хэсгийн гишүүн
3. Батбаяр, Баясалтөгс ХХК-ийн инженер; Ариунболд ЦДҮС ТӨХК-ийн инженер
4. Г. Цэрэнханд (СИА ХХК),
5. Л. Цэлмэгсайхан (IRIM),
6. Н. Янжинпагма (IRIM)

**Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал**

#	Хурлын хөтөлбөр	Хэлэлцэх асуудал
1	Нийгмийн судалгааны баг хээрийн судалгааны төлөвлөгөө, зорилтот оролцогч талуудыг танилцуулна.	Талбайн тандалт судалгааны ажиглалтын талаар товч мэдээлж, нийгмийн суурь судалгааны ажлын төлөвлөгөөг танилцуулав.
2	Төслийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг нийгмийн судалгааны багт өгөх (Эхлэх хугацаа, ажиллах хүчний талаарх мэдээлэл тодорхой болсон бол).	Дашдаваа: ЦДШ барих шийдвэрийг засгийн газрын төвшинд гаргасан. Мөн төсөл хэрэгжүүлэх газрын шийдвэрийг хоёр аймгийн захиргаа гаргасан, одоогийн байдлаар сумдын ИТХ-ын албан ёсны шийдвэрийг 2020 оны 5-р сарын 15-ныг хүртэл хүлээж байна. Олон хүн цуглуулж болохгүй тухай Ковид 19-н хязгаарлалт, хурлын гишүүнээр сонгогдсон малчид суманд олон байдаг ба малчдын хувьд шинээр төллөсөн мал, ноолуур самнах улирал зэрэг ачаалал ихтэй үе мөн таарч байгаа учраас хурлаа явуулж чадаагүй байна. 2020 оны 5-р сарын 12-ны байдлаар 4 сумын шийдвэр (Сайншанд, Айраг, Алтанширээ) гарсан ба Шивээговь, Сайхандулаан сумын шийдвэр энэ долоо хоногт гарна, харин үлдсэн нэг сум болох Сүмбэр сумын шийдвэр ирэх долоо хоногт гарах төлөвлөгөөтэй байна.
3	Төслийн талаар ямар мэдээллийг ороцлогч талуудтай хуваалцах, оролцогч талуудын асуултанд хариу өгөх хүмүүсийг ЦДҮС / Ажлын хэсэгтэй ярилцаж, баталгаажуулах.	Төслийн ерөнхий явцын талаар Эрчим хүчний яамны стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ажлын хэсгийн ахлагчт Энхтайвантай зөвлөлдөх шаардлагатай байна..
4	Нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын тасалбар болгох огноог ЦДҮС / АХ-тэй баталгаажуулах	Тодорхой биш. (Тэмдэглэл: АХ-д мэдээлэх)
5	Сум, багийн олон албан тушаалтнууд төслийн тухай мэдээлэлгүй байсан, тэдэнд ЦДҮС / АХ-ээс албан тоотыг илгээнэ үү? Мөн түүнчлэн багийн	Албан тоотыг Эрчим хүчний яамнаас АХ-ийн нарийн бичгийн дарга Лувсанцэрэнгээр дамжуулан авах боломжтой.

	<p>зарим дарга нар төслийн зөвлөхүүдэд мэдээлэл өгөхөд аймгийн холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авах шаардлагатай байгааг мэдэгдэв. Тиймээс ажлын хэсгээс энэ талаар нэмэлт албан тоот явуулах шаардлагатай юу?</p>	<p>Бүх долоон сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2020 оны 5-р сарын 15-ны дотор газар ашиглалтын асуудлаар албан ёсны шийдвэр гаргаснаас хойш бүх шатны албан тушаалтнууд, мэргэжилтнүүд энэхүү албан ёсны шийдвэрийг дагаж мөрдөж, холбогдох оролцогч талууд, түүний дотор Нийгмийн судалгааны багтай хамтарч ажиллах төлөвтэй байна.</p>
6	<p>Тодорхой бүлгүүдтэй нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой хүлээгдэн гарах асуудлуудыг төлөвлөсөн. ЦДҮС / АХ-ээс гэрээ байгуулах хэрэгтэй</p> <ul style="list-style-type: none"> <li>◦ ЦДШ-д ойрхон (3-5 км хүртэлх зай нь тухайн газар нутгийн бэлчээр ашиглагчид байж болно)</li> <li>◦ Дэд станцад холбогдох цахилгаан дамжуулах агаарын шугамын ойр байрлах бизнес үйлчилгээ/ үйлдвэр (Чойр, Сайншанд)</li> <li>◦ Суурин газрын нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхүүд</li> <li>◦ Аймаг, орон нутгийн төвшинд</li> </ul>	<p>Компани нь 25 метрын хамгаалалтын зурваст тавигдах Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрддөг. Түүнчлэн, ЕСБХБ-ын шаардлагыг хангаж, шугамын хоёр тал дахь 3 км бүс байхад асуудалгүй гэж үзсэн.</p> <p>Баясалтөгс ХХК нь 2013 онд цахилгаан дамжуулах агаарын шугамын маршрутын газрын зургийг боловсруулж, 2020 онд шинэчлэсэн. Хоёр аймагт очих үеэр шугамын маршрутын хоёр талын 25 м-т багтаж байгаа малчин өрх, малчдын сууц, объект, худаг, бизнес, үйлчилгээний газар, үйлдвэр, уурхайн лицензит газар байхгүй болохыг баталгаажуулсан. Дэд станц, шугамын замын газар эзэмших зөвшөөрөл олгохдоо аймгийн газрын албанаас давхардсан газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын лицензит газар байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан. Ашиглалтын лицензтэй давхцаж болзошгүй тохиолдолд хуульд зааснаар Засгийн газар төрийн тусгай зориулалтаар ашиглах газрыг авах эрхтэй (зам гэх мэт).</p>
7	<p>Оролцогч талуудын оролцоог хангах менежмент:</p> <ul style="list-style-type: none"> <li>◦ Компанийн орон нутгийн оролцогч талуудтай (орон нутгийн засаг захиргаа, бизнес, олон нийт, малчид гэх мэт) хийсэн аливаа оролцоо- огноо, оролцооны хэлбэр.</li> <li>◦ Компанид гомдол шийдвэрлэх албан механизм бий юу?</li> <li>◦ Мэдээлэл лавлагаа, гомдол шийдвэрлэх тохиолдолд Компаниас хэн Төслийг төлөөлж ажиллах вэ?</li> </ul>	<p>Аймгийн газрын албатай хийсэн уулзалтаас бусдаар Компанийн орон нутгийн оролцогч талуудтай явуулсан оролцоо хангах үйл ажиллагаа байхгүй. (Ариунболдоос асууж тодруулах шаардлагатай) Эрчим хүчний тухай хуульд зааснаар Эрчим хүчний зохицуулах хороо нь аливаа гомдол, гомдол шийдвэрлэх асуудлыг хариуцдаг ганц байгууллага юм. Аймаг бүр гурван хүний бүрэлдэхүүнтэй комиссын салбар хороотой бөгөөд аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулдаг. Компанийн зүгээс Зохицуулах хорооны Гомдол шийдвэрлэх механизмын тэргүүлэх үүргийг хариуцах хүнийг компаниас томилохгүй гэж Дашдаваа үзэж байна.</p>

8	<p>Ложистикийн ажил:</p> <p>Сүүлийн үеийн туршлага дээр үндэслэн нийгмийн судалгааны баг нь газар ашиглалтын талаар шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл цуглуулахад Засгийн газрын дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт гарган Аймгийн засаг даргын тамгын газар, аймгийн Цагдаагийн газар, Газрын албанд албан тоот хүргүүлэх шаардлагатай. Компани / Ажлын хэсгээс Аймгийн Онцгой байдлын албанд хөл хорионд орох тохиолдолд ажлын хэсгийн мэдээллийг бүртгэн Улаанбаатарт буцаж ирэхэд судалгааны багийн ажилд дэмжлэг үзүүлэх талаар албан тоотыг хүргүүлэх. (томилолтоор явж байгааг баталгаажуулах албан бичиг)</p>	<p>Дэмжлэг үзүүлэх хүсэлтийн албан тоотыг Эрчим хүчний яамнаас АХ-ийн нарийн бичгийн дарга Лувсанцэрэнгээр дамжуулан авах.</p>
9	<p>Кетигийн асуулт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тэд шинэ шугамын хамгаалалтын зурвасыг судалж тогтоосон уу? Түүний дотор, тухайлбал хоёр хотод ямар барилгууд байгааг баталгаажуулж чадах уу?</li> <li>- Батлагдсан хамгаалалтын зурвасын бүтцийг дахин байршуулахаар төлөвлөж байна уу?</li> <li>- Кандис: Уул уурхай ашиглалтын эрх бүхий нэгэн газар / байршлын талаар дурдав. – Байршил, тулгамдсан асуудлуудыг олж мэдэхийн тулд тэдэнтэй холбогдож асууж тодруулах шаардагатай гэж хэллээ.</li> </ul>	<p>6-р мөрийг харах</p>

Нэмэлт санал хүсэлт:

Сөрөг нөлөө – Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө. Хэдийгээр одоогийн Хамгаалалтын зурвасыг цахилгаан соронзон орны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар нотолгоонд суурилсан шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн тогтоосон хэдий ч бусад сөрөг нөлөөг тодруулах шаардлагатай.

Томоохон сөрөг нөлөө - Нүүдлийн шувуудад; шувууд өндөр хүчдэлийн цахилгааны шугамд 2 метр хүртэл ойртоход л өндөр хүчдэлд цохиулах эрсдэлтэй байдаг.

Зам хөндлөн гарах – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тусгай дүрэм журам бий;

ТХН-ийг яамнаас байгуулах төлөвтэй байна; Компани нь барилгын ажилд хяналт тавьж ажиллана. (Аюулгүй ажиллагааны дүрэм журам, Хамгаалалтын зурвас газрын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг дагаж мөрдөх гэх мэт.)

Баясалтөгс ХХК-ийн Инженер Батбаяр - 2013, 2020 онд Хамгаалалтын зурваст малчин өрх байхгүй, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцаагүй.